

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫН УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Уг судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу гүйцэтгэв.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ.

1. Монгол Улсын Их Хурлын 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.4-т “Тогтвортой хөгжлийн засаглал”-д “төвлөрлийг сааруулж, шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангах;” гэж, 2.4-ийн зорилго 2-т “Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ.” гэж; Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.1.19-т “Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх бодлого баримталж, хэрэгжилтийг хангах эрх зүйн орчинг цогцоор бүрдүүлнэ.” гэж; Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор батлагдсан “Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого”-ын 3.1.1-д “нутгийн удирдлагын байгууллагын бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд болон иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх замаар улс төрийн төвлөрлийг сааруулах;” , 3.1.4-т “төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, төрийн болон орон нутгийн байгууллагын зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, нийгмийн салбарын хувьчлалыг үргэлжлүүлэх замаар эдийн засгийн төвлөрлийг сааруулах.” 4.1-ийн 2-т “төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын чиг үүргийн 20-иос доошгүй хувийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж эхэлсэн байна;”, 4.2.1-т “яам, Засгийн газрын агентлаг, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын чиг үүргийг ангилж, зайлшгүй шаардлагатайгаас бусад чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж нийтийн албаны чиг үүргийг оновчтой болгосон байна;” гэж тус тус зааж төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих зохицуулалтыг тусгаж өгсөн байна.

Гэсэн хэдий ч төрийн бодлого төлөвлөлтөд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх талаар төрийн бус байгууллагын оролцоог хангах, бэхжүүлэх, үйл ажиллагааны цар хүрээг тодорхой болгох зэрэг шаардлага тавигдаж байна. Иймд Аргачлалын 3-т заасны дагуу дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

1.Тодорхой салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, мэргэшсэн хувь хүн, ашгийн төлөө байгууллагын оролцоотойгоор мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулагдах эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

2. Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа тогтвортой, мэргэшсэн байх нөхцөл бүрдүүлэх;

3.Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа бэхжүүлж төрийн зарим чиг үүргийг энэхүү хуулийн дагуу байгуулагдах гэрээний эсхүл хуулийн дагуу гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлэх;

4.Төрийн байгууллагын хэт төвлөрсөн чиг үүргийг задалж, зарим чиг үүргийг илүү мэргэшсэн түвшинд гүйцэтгэх боломж бүрдүүлэх;

5.Төрийн байгууллагын шийдвэр гаргалтад иргэний нийгмийн ялангуяа мэргэжлийн байгууллагын үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэх, зохистой төвшинд хүргэх;

6.Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааны сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх.

1.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох:

Үүсээд байгаа дээр дурдсан асуудалтай холбоотойгоор дараахь бүлгийн эрх, ашиг сонирхол хөндөгдөж байна

Хууль ёсны эрх ашиг, сонирхол хөндөгдөх байдал

№	Эрх ашиг нь хөндөгдөж буй бүлэг	Эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхол ямар байдлаар нөлөөлж байгаа байдал
1.	Төрийн байгууллага: <ul data-bbox="316 1373 868 1638" style="list-style-type: none">• Засгийн газар • Салбарын төрийн захиргааны төв байгууллага	Засгийн газрын үйл ажиллагааны мэргэжлийн үйл ажиллагааны чадамж нэмэгдэх, төрийн чиг үүргийн хэт төвлөрлийг сааруулах, зардал хэмнэх Салбарын мэргэжлийн холбоонд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, иргэний нийгмийн байгууллагатай хамтын ажиллагаа сайжрах, мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаанд 5 жил тутамд итгэмжлэл олгох

2.	<ul style="list-style-type: none"> Мэргэжлийн нэгдсэн холбоо 	Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүн нь салбарт хамаарах мэргэжлийн чиглэлээр байгуулагдсан төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, мэргэшсэн хувь хүн байна.
----	-----------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Төрөөс мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааг бэхжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл:

Холбогдох мэдээллийг харьцуулан дүгнэхэд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн хэрэгжилтийн явцад маргаантай, шийдвэл зохих дараахь асуудлууд байсаар байна:

Манай улсад анх 1997 онд Төрийн бус байгууллагын тухай хууль батлагдсанаар иргэний нийгмийн байгууллагууд байгуулагдах эрх зүйн үндэслэл бүрдсэн.

Монол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1-д “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.” гэж зааснаар төрийн болон төрийн бус байгууллага хамтран ажиллах боломж нээгдсэн.

Үүний дагуу барилгын, эрүүл мэндийн зэрэг зарим салбарт төрийн байгууллагын гүйцэтгэх үйлчилгээний буюу зохион байгуулалтын чиг үүргийг Засгийн газар тогтоол гаргах замаар төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байна. Гэсэн хэдий ч төрийн бодлого төлөвлөлтөд мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагатай хамтрах, саналыг нь тусгах, мэргэжлийн удирдамж, арга зүйн зөвлөмжөөр хангах чиглэлийн үйл ажиллагаа доголдолтой байна.

Төрөөс төрийн бус байгууллагатай зөвлөх үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллаж буй байдлыг авч үзвэл тодорхой хугацаанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх ажлууд байх ба урт хугацааны үр дүнтэй хамтын ажиллагаа төдийлөн бэхжиж чадахгүй байна. Үүний улмаас нэг талаас төрийн байгууллагууд бодлого боловсруулах, тодорхойлох зэрэг үндсэн чиг үүргээ гүйцэтгэж чадахгүй, худалдан авалт, сургалт, сурталчилгааны компани ажил зохион байгуулах, тусгай зөвшөөрөл олгох зэрэг зохион байгуулалтын шинжтэй буюу хууль, гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болох ажлаар хүний нөөцөө шавхаж байна.

Харин нөгөө талаас манай улсад бүртгэлтэй мэргэжлийн гэх тодотголтой төрийн бус байгууллагууд тогтвортой, идэвхитэй үйл ажиллагаа явуулдаггүйгээс тэдгээр байгууллагад төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэхийн оронд орон тооны бус зөвлөл ажиллуулах, зарим тохиолдолд зөвлөхийн ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх төдийхнөөр хязгаарлаж байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна. Хуулийн төслийг боловсруулах зорилго нь мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааны зохион байгуулалт, чиг үүрэг, эрх зүйн байдлыг тодорхойлох, төрийн болон бусад төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, харилцахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааны зохион байгуулалт, чиг үүрэг, эрх зүйн байдлыг тодорхойлох, төрийн болон бусад төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, харилцахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараахь дүгнэлтийг гаргалаа.

“Тэг” хувилбар буюу зохицуулалт хийхээс татгалзах” - Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа бэхжих нөхцөл хангалтгүй тул төрөөс тодорхой зохицуулалт зайлшгүй шаардлагатай учир энэ хувилбарыг сонгох боломжгүй.

“Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх” - тохиромжгүй хувилбар.

“Төрөөс санхүүгийн интервенц хийх” - тохиромжгүй хувилбар.

“Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх” – хэдийгээр хууль тогтоомжид энэ талаар тусгасан байдаг хэдий ч нарийвчилсан зохицуулалт байхгүй тул энэ зохицуулалт хэрэгжих боломжгүй.

“Захиргааны шийдвэр гаргах” - Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд заасан Захиргааны акт хэлбэрээр шийдвэрлэх нь тохиромжгүй гэж үзсэн тул сонгох боломжгүй.

“Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх” болон “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” гэсэн 2 хувилбарыг сонголоо.

Сонгосон хувилбарын зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцааны эерэг, сөрөг талыг харьцуулан судалвал:

Хүснэгт 1

Зохицуулалтын хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
------------------------	-----------------------	-----------------------------

1.Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Хэдийгээр төрийн бус байгууллагууд болон мэргэшсэн хувь хүн, бусад салбарын аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг дэмжих боломжтой ч үйл ажиллагааны сахилга, хариуцлагыг зохицуулах боломжгүй.	Зардал хууль тогтоомжийн төсөл боловсруулахтай адил гарна. Асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй хувилбар
2.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Нэг талаас мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа, сахилга хариуцлага бэхжих ба төрийн байгууллага болон МНХ-ны хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжтой.	Зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг шийдвэрлэхэд оновчтой хувилбар.

“Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” – хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар дараах асуудлыг шийдвэрлэх боломжтой тул энэ хувилбарыг сонгов. Үүнд:

1. Мэргэжлийн нэгдсэн холбооны тогтолцоо, зохион байгуулалт чиг үүргийг тодорхой тусгах;
2. Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааг дэмжих талаарх төрийн байгууллагын чиг үүргийг тодорхой болгож, хамтын ажиллагааг бэхжүүлэх боломж бүрдэх;
3. Мэргэжлийн нэгдсэн холбоо болон төрийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгох.

Уг хуулийн төсөл боловсруулахтай уялдуулан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДЛАХ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа. *Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.*

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Тухайн салбарын мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулагдсанаар тус салбарт үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой иргэд, аж ахуйн нэгжүүд мэдээлэл авах боломж нэмэгдэх,

хамтын ажиллагаа сайжрах зэргээр Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Эдийн засагт ачаалал үүсгэхгүй бөгөөд урт хугацаанд тухайн салбарын иргэд, аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагаа сайжрах, эрт хугацаанд эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй..

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Сонгосон хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, бусад хуультай бүрэн нийцэж байгаа болно.

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, Олон улсын хэм хэмжээний жишиг зэргийг харьцуулан дүгнэхэд дурдсан асуудлуудыг хууль боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой юм.

ЗУРГАА.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Төрийн зарим чиг үүргийг хууль гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж буй олон улсын практикаас үзвэл ихэвчлэн төрийн бус байгууллагын хариуцлага, төлөвшил харьцангуй өндөр хөгжсөн улс орнууд уг зохицуулалтыг илүүтэйгээр ашиглаж байна. Энэ нь нэг талаас хамтын ажиллагааг бэхжүүлж, төрийн зарим ачаалал багасч,нөгөө талаас төрийн уг ажиллагааг хэрэгжүүлэхэд гарах зардлыг

хэмнэх боломж гэж үздэг байна. Дурдсан харилцааг зохицуулж буй ХБНГУ болон Канад улсын туршлагыг авч үзье.

Уг судалгааг зөвхөн гадаад улс орнуудын төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг хэрхэн тодорхойлсныг авч үзсэн болно.

ХБНГУ-ын зохицуулалт:

ХБНГУ нь 1990 оноос төрийн байгууллагын чиг үүргийн төвлөрлийг сааруулах бодлого баримталж ирсэн ба төрийн захиргааны зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн аль алианаар нь хэрэгжүүлүүлэх талаар нарийвчилсан зохицуулалт байдаг бөгөөд эрх зүйн зохицуулалт нь бүрдсэн.

Төрийн зарим чиг үүргийг хууль, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч нь төрийн тухайн чиг үүргийг шилжүүлэн авч байгаагийн хувьд үйлчилгээ үзүүлэгч этгээдэд төрийн өмнөөс хариуцлага хүлээж, харин олгогдсон эрхийн хүрээнд төрийн байгууллага шууд хамаарч ажилладаг байна. Ингэхдээ хоорондын эрх үүргийн харилцаагаа талууд хоорондын нарийвчилсан зохицуулалт бүхий гэрээгээр зохицуулдаг байна.

ХБНГУ-ын хувьд нийгмийн харилцааны нийтлэг салбарт төдийгүй онцгой салбар болох нийтийн аюулгүй байдлын салбарт ч төрийн зарим чиг үүргийг бие даасан хараат бус этгээдээр гүйцэтгүүлэх зохицуулалт байдаг байна.

Харин уг этгээдийг тухайн ажил үүргийн чиг үүрэгт тохирсон байдал (найдвартай эсэх), чадавхи, мэргэжлийн чадвар зэргийг харгалзан тэгш өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулдаг ба шалгарсан этгээд нь өөрт олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд захиргааны акт гаргах, хураамж авах болон бусад захирамжлах эрхийг хэрэгжүүлж болдог байна.

Канад улсын зохицуулалт

Эрх зүйн зохицуулалтын хувьд мөн л 1990-ээд оноос төр хувийн хэвшлийн түншлэл хэрэгжиж эхэлсэн байна. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлийн байгууллагаар гэрээ эсхүл хуулийн үндсэн дээр гүйцэтгүүлэх харилцааг хувьд Канадын Холбооны хууль болон мужуудын хуулиар зохицуулдаг байна.

Канадын Стратегийн дэд бүтцийн санхүүгийн тухай хууль болон бусад хуульд зааснаар салбарын сайд нь тухайн байгууллагыг тодорхой чиг үүргийг гүйцэтгэх чадамжтай эсэх эсхүл гишүүн байгууллагууд нь тийм чадамжтай эсэхийг нягталж, зөвшөөрсөн байх шаардлагатай. Түүнчлэн байгууллага өөрөө эрх зүйн чадамжтай эсэх нь шийдвэр гаргалтад мөн нөлөөлдөг байна.

Түүнчлэн зарим улс орнуудад төрийн бус байгууллагуудын нийгэмлэгийн талаар бие даасан хуулиар үүсгэн байгуулах, бүртгэх, санхүүжүүлэх зэрэг цогц харилцааг зохицуулж байна. Энэ хувилбар нь нэг талаар нэг байгууллагад давамгайл байдал үүсгэж болзошгүй байж болохоор байна. Гэвч төрийн бус байгууллагын үйл ажиллагааны соёл, тогтвортой байдал төлөвшөөгүй нөхцөлд бие даасан хуулиар уг харилцааг зохицуулах нь

илүү давуу талтай гэж үзлээ.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, төрийн болон орон нутгийн байгууллагын зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх зорилтыг хангахын тулд мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааны зохион байгуулалт, чиг үүрэг, эрх зүйн байдлыг тодорхойлох, төрийн болон бусад төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, харилцахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан эрх зүйн үндсийг бий болгох.
2. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулахтай холбогдуулан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах зөвлөмжийг хүргүүлж байна.
3. Хуулийн төсөл батлагдсанаар төсөлд дурдагдсан захиргааны хэм хэмжээний актыг батлан мөрдүүлэх шаардлагатай гэж үзэв.
4. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид мэргэжлийн нэгдсэн холбоо нь төрийн бус байгууллагын хувьд төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх зохицуулалт тодорхой хэмжээгээр туссан боловч уг ажиллагааг эрчимжүүлэх, бэхжүүлэх, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зохицуулалт байхгүйгээс хуулийн дээрх зохицуулалт үр дүнгүй болж байна. Иймд шинээр хууль боловсруулах шаардлагатай юм.

-----000-----

Хавсралт

Хүснэгт №1

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцоо боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ,	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх			
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	тодорхойлсон
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Энэ харилцаанд хамаарах этгээдийн үүргийг тодорхойлсон
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал,	Тийм	Үгүй	Бүртгэл, мэдээ, тайлан гаргах шаардлага үүснэ.

захиргааны зардлын ачаалал	мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх			
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	хамтын үйл ажиллагааны үр дүнд боломж бүрдэх боломжтой.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Мэргэжлийн нэгдсэн холбоонд зөвшөөрөл олгох, итгэмжлэл олгох
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хяналттай хамтын ажиллагаа бэхжинэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх нөлөө:	Үр	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар		1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч		2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах		3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй..
		3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц		4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй